

# Аудитын дүгнэлт

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН  
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ**

**СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР ТАНАА**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг үндэслэн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулгад аудит хийв.

**Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл**

Төсвийн ерөнхий менежер санхүүгийн тайлангуудыг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаал болон холбогдох заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг. Мөн НББ-ийн батламж мэдэгдлүүдийн дагуу тулган баталгаажуулах, түүвэрлэх аргуудыг ашигласан.

**Мөнгөн гүйлгээний тайлан**

Улсын төвлөрсөн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 66768.3 мянга, орон нутгийн төсвөөс урсгал засварт 3000.0 мянга, судалгааны орлого 60790.3 нийт 130558.6 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого орж гүйцэтгэлээр үйл ажиллагааны 130558.6 мянган төгрөгийн зардал гарч, үлдэгдэлгүй гарчээ.

**Үр дүнгийн тайлан**

Улсын төвлөрсөн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 66768.3 мянга, орон нутгийн төсвөөс 3000.0 мянга, судалгааны орлого 60790.3, хөрөнгийн орлого 1119.2 мянга нийт 131677.9 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого орж гүйцэтгэлээр 138716.4 мянган төгрөгийн зарлага гарч 7038.5 мянган төгрөгийн үр дүнгүй ажиллажээ.

### Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаанд хуримтлагдсан үр дүн 7038.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, засгийн газрын оруулсан капитал 17759.1 мянган төгрөг болжээ.

### Байдлын тайлан

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдэлийг тулган баталгаажуулж нийт балансын тэнцвэр 17759.1 мянган төгрөгөөр илэрхийлэгдлээ.

### Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2013 онд улсын төвлөрсөн төсвөөс 66768.3 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч гүйцэтгэлээр 66513.6 мянган төгрөгийн зарлага гарчээ. Санхүүжилт болон бодит гүйцэтгэлийн зөрүүг авч үзвэл: төсвийн хэмнэлтийн төвлөрүүлэлт 254.7 мянга төгрөгийн эх үүсвэрт тохируулга хийж, төсвийн гүйцэтгэл 66513.6 төгрөг болжээ.

### Өмнөх СТА-ын зөвлөмжийн биелэлт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй.

Санал дүгнэлт 2013 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан болон тодруулгууд УСНББОУС дагуу үнэн зөв шудрага илэрхийлэгдсэн байдалд зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Сүхбаатар аймгийн Аудитын газар

Аудитор  
Шинжээч

А.Мөнхцэцэг  
Э.Алтансүх

УХА0122

Статистикийн хэлтсийн

Дарга  
Няглан бодогч

Т.Эрдэнэбат  
Ц.Азжаргал

Л10А0030